

ГХБХБГ-ЫН 03 ДУГААР САРЫН 3 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

2020.03.19.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ 7 хоногт шинээр газар эзэмшихийг хүссэн 1 иргэний хүсэлт болон холбогдох материалын хамт хүлээн авч аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж ЗДТГ-т хүргүүлэв. Мөн эзэмшил газрын талбайн хэмжээг кадастрын зургийн дагуу өөрчлүүлэхийг хүссэн 2 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг холбогдох материалын хамт хүлээн авч аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж ЗДТГ-т хүргүүлэв.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 1 иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээ шинээр олгож гэрээ байгуулав.</p> <p>Сумдын газрын даамлуудтай хамтран 114 иргэний газар өмчлөх, эзэмших нэгж талбарын хувийн хэргийг нөхөн бүрдүүлэлт хийж, 277 нэгж талбарын цахим архивыг газрын кадастрын Лэндменежер програмд оруулав.</p> <p>“Өлгийланд”, “Эл эм ланд” ХХК-ын хийсэн 9 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдээллийн санд оруулсан болно.</p> <p>Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 2 газрын кадастрыг хянаж баталгаажуулав.</p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Баяннуур сумын Цэцэгт багийн төвд баригдах бага сургуулийн барилгад архитектур төлөвлөлтийн даалгавар олгов.</p> <p>Өлгий сумын 3,4,11-р багуудад баригдах тоглоомын талбайн байршлын схемийг батлав.</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

<p>Аймгийн шүүхийн байрны их засварын схем зургийг батлав.</p> <p>Сагсай сумын халуун усны барилгын эскиз, ажлын зургийг батлав.</p> <p>2016-оноос хойш олгогдсон архитектур төлөвлөлтийн даалгаврыг жижүүрийн хөтлөлт хариуцсан мэргэжилтэнд гарган өгч мэдээллийн санд оруулахад хяналт хийв.</p>		
---	--	--

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР